



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/33/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Майцэцэг

Утас: 70273204 Цахим хаяг: maitsetsegt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага	17
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2023.02.25 № 01/72
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр баримтлах бодлого хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэн, тайлант онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын даргатай байгуулсан гэрээний биелэлт 96,2%, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт 96,4 %-тай хэрэгжсэн байна.

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласнаар цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын болон бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг хэмнэж, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 53,739.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,033,447.53	31,108,593.64
33	АВЛАГА	7,598,950.00	3,838,556.11
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	180,000.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	7,418,950.00	3,838,556.11
35	БАРАА МАТЕРИАЛ	40,434,497.53	23,970,037.53
351	Түүхий эд материал	14,049,000.00	00.00
35110	Тусгай зориулалттай материал	14,049,000.00	00.00
354	Хангамжийн материал	26,385,497.53	23,970,037.53
35410	Бичиг хэргийн материал	1,044,200.00	00.00
35420	Аж ахуйн материал	23,760,047.53	23,970,037.53
35440	Түлш, шатах тослох материал	1,581,250.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,718,624,323.82	1,574,231,846.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,718,624,323.82	1,574,231,846.95
392	Биет хөрөнгө	1,662,164,323.82	1,514,271,846.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,787,363,920.24	1,787,363,920.24
39202	Хуримтлагдсан элэгдэл	-303,008,544.72	-382,527,619.24
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,104,166.39	-13,266,666.31
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	396,106,128.73	404,321,328.73
39206	Хуримтлагдсан элэгдэл	-271,086,956.88	-332,330,856.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	111,538,157.01	112,582,750.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-78,644,214.17	-91,871,010.21
393	Биет бус хөрөнгө	56,460,000.00	59,960,000.00
39301	Програм хангамж	3,952,468.70	7,452,468.70
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,952,468.70	-3,952,468.70
39303	Бусад биет бус хөрөнгө	56,460,000.00	56,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,766,657,771.35	1,605,340,440.59
41366	Дансны өглөг /ТӨҮГ/		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,766,657,771.35	1,605,340,440.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,766,657,771.35	1,605,340,440.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон	1,070,976,822.90	1,070,976,822.90
51101	Өмч: - төрийн	1,070,976,822.90	1,070,976,822.90
512	Хуримтлагдсан үр дүн	694,952,629.79	533,635,299.03
51210	Өмнөх үеийн үр дүн	694,952,629.79	694,952,629.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	728,318.66	728,318.66
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,766,657,771.35	1,605,340,440.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	617,933,933.00	748,969,598.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	54,927,553.00	2,889,550.00
120	Нийтлэг татварын бус орлого	54,927,553.00	2,889,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,927,553.00	2,889,550.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54,927,553.00	2,889,550.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,006,380.00	746,080,048.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	295,642,400.00	694,398,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	295,642,400.00	694,398,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,042,580.00	51,681,348.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс	00.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	32,074,000.00	3,404,643.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	16,968,580.00	47,976,705.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	218,321,400.00	00.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	691,054,744.29	910,286,928.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	691,054,744.29	910,286,928.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	647,384,313.27	803,558,683.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	134,883,515.00	224,799,172.96
210101	Үндсэн цалин	97,278,291.90	153,175,858.72
210102	Нэмэгдэл	30,476,635.51	24,315,389.30
210105	Гэрээт ажлын хөлс	7,128,587.59	24,403,667.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,608,638.45	28,639,200.70
210201	Тэтгэврийн даатгал	12,849,989.83	19,854,096.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,322,441.22	2,286,275.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	951,423.34	1,758,460.74
210204	Ажилгүйдлийн даатгал	940,552.58	429,652.03
210205	Эрүүл мэндийн даатгал	2,544,231.48	4,310,715.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,075,089.40	240,324,676.00
210301	Гэрэл, цахилгаан	6,190,905.00	8,338,418.00
210302	Түлш, халаалт	201,346,282.40	217,968,593.20
210303	Цэвэр, бохир ус	8,537,902.00	14,017,664.80
2104	Хангамж, бараа материалын зардал	11,147,305.06	9,469,609.76
210401	Бичиг хэрэг	2,075,420.00	4,036,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,400,000.00	2,142,969.76
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	817,690.00	1,546,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	446,000.00	1,503,600.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	6,168,195.06	00.00
2105	Нормативт зардал	390,650.00	348,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	390,650.00	348,600.00
2107	Томилолт, зочны зардал	572,000.00	1,868,000.00
210702	Дотоод албан томилолт	572,000.00	1,868,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	115,579,548.30	130,008,354.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	113,517,251.30	127,385,673.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	696,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	420,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,744.00	87,744.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	541,330.00	1,056,600.00
210807	Газрын төлбөр	382,223.00	185,737.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,127,567.06	158,655,269.87
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,708,500.00	1,503,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	147,419,067.06	157,152,269.87
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,670,431.02	106,728,245.03
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	43,670,431.02	53,739,645.03
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	43,670,431.02	53,739,645.03
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-73,120,811.29	-161,317,330.76
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-73,120,811.29	-161,317,330.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	563,006,380.00	756,798,998.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,300,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,300,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	3,300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,300,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	563,006,380.00	753,498,998.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	295,642,400.00	694,398,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	295,642,400.00	694,398,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,042,580.00	59,100,298.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,718,950.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	32,074,000.00	3,404,643.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,968,580.00	47,976,705.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	218,321,400.00	01.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	563,006,380.00	743,024,405.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	563,006,380.00	743,024,405.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	511,916,998.98	632,457,603.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,569,644.53	228,099,172.96
210101	Үндсэн цалин	97,555,671.43	156,475,858.72
210102	Нэмэгдэл	30,476,635.51	24,315,389.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	10,989,750.00
210104	Урамшуулал	00.00	11,914,507.50
210105	Гэрээт ажлын хөлс	7,537,337.59	24,403,667.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,922,508.92	28,639,200.70
210201	Тэтгэврийн даатгал	12,760,260.11	19,854,096.10
210202	Тэтгэмжийн даатгал	1,322,441.22	2,286,275.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,041,153.06	1,758,460.74
210204	Ажилгүйдлийн даатгал	254,423.05	429,652.03
210205	Эрүүл мэндийн даатгал	2,544,231.48	4,310,715.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,075,089.40	240,324,676.00
210301	Гэрэл, цахилгаан	6,190,905.00	8,338,418.00
210302	Түлш, халаалт	199,680,126.40	217,968,593.20
210303	Цэвэр, бохир ус	10,204,058.00	14,017,664.80
2104	Хангамж, бараа материалын зардал	6,420,090.00	8,070,190.00
210401	Бичиг хэрэг	3,029,620.00	2,689,050.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,079,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	909,820.00	1,677,140.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440,650.00	2,384,200.00
2105	Нормативт зардал	396,000.00	265,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	396,000.00	265,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	572,200.00	8,746,240.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,488,950.00
210602	Тавилга	00.00	135,900.00
210604	Урсгал засвар	572,200.00	7,121,390.00
2107	Томилолт, зочны зардал	572,000.00	628,000.00
210702	Дотоод албан томилолт	572,000.00	628,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	131,217,401.13	113,696,024.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	129,114,234.13	111,254,343.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	696,000.00	756,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.00	420,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,744.00	87,744.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,200.00	925,600.00
210807	Газрын төлбөр	382,223.00	185,737.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,172,065.00	3,988,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,580,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,172,065.00	2,408,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,089,381.02	110,566,801.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	52,988,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	52,988,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	51,089,381.02	57,578,201.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	13,774,593.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	10,474,593.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	10,474,593.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	10,474,593.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	10,474,593.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-10,474,593.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	3,300,000.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,300,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,070,976,822.90	728,318.66	694,952,629.79	00.00	1,766,657,771.35
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,070,976,822.90	728,318.66	694,952,629.79	00.00	1,766,657,771.35
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,070,976,822.90	728,318.66	694,952,629.79	00.00	1,766,657,771.35
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-161,317,330.76	00.00	-161,317,330.76
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,070,976,822.90	728,318.66	533,635,299.03	00.00	1,605,340,440.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	694,398,700.00	640,659,054.97	53,739,645.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	694,398,700.00	640,659,054.97	53,739,645.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	641,410,100.00	587,670,454.97	53,739,645.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	244,478,300.00	200,283,293.76	44,195,006.24
210101	Үндсэн цалин	183,307,900.00	153,168,327.96	30,139,572.04
210102	Нэмэгдэл	27,675,900.00	24,315,389.30	3,360,510.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,758,000.00	10,989,750.00	-231,750.00
210104	Урамшуулал	22,736,500.00	11,809,826.50	10,926,673.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,559,800.00	25,391,647.81	5,168,152.19
210201	Тэтгэврийн даатгал	20,961,000.00	17,522,922.42	3,438,077.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,399,700.00	2,056,826.16	342,873.84
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,919,800.00	1,574,900.98	344,899.02
210204	Ажилгүйдлийн даатгал	479,900.00	385,181.63	94,718.37
210205	Эрүүл мэндийн даатгал	4,799,400.00	3,851,816.62	947,583.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	237,199,500.00	237,199,499.20	00.80
210301	Гэрэл, цахилгаан	19,264,400.00	8,188,621.00	11,075,779.00
210302	Түлш, халаалт	208,302,900.00	214,993,213.40	-6,690,313.40
210303	Цэвэр, бохир ус	9,632,200.00	14,017,664.80	-4,385,464.80
2104	Хангамж, бараа материалын зардал	4,265,800.00	4,251,990.00	13,810.00
210401	Бичиг хэрэг	852,900.00	946,000.00	-93,100.00
210402	Тээвэр, шатахуун	1,228,100.00	1,079,800.00	148,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	818,700.00	979,390.00	-160,690.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	171,500.00	240,000.00	-68,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,194,600.00	1,006,800.00	187,800.00
2105	Нормативт зардал	275,500.00	265,400.00	10,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	275,500.00	265,400.00	10,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	306,200.00	296,400.00	9,800.00
210604	Урсгал засвар	306,200.00	296,400.00	9,800.00
2107	Томилолт, зочны зардал	803,000.00	628,000.00	175,000.00
210702	Дотоод албан томилолт	803,000.00	628,000.00	175,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,113,800.00	116,946,024.20	4,167,775.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	118,134,800.00	114,504,343.20	3,630,456.80
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,400.00	756,400.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	420,200.00	420,200.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	252,100.00	87,744.00	164,356.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	66,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	963,300.00	925,600.00	37,700.00
210807	Газрын төлбөр	521,000.00	185,737.00	335,263.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2408200.00	2408200.00	00.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,408,200.00	2,408,200.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	52988600.00	52988600.00	00.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,988,600.00	52,988,600.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	52,988,600.00	52,988,600.00	00.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	694,398,700.00	640,659,054.97	53,739,645.03
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	694,398,700.00	640,659,054.97	53,739,645.03
131001	Улсын төсвөөс санхүүжих	694,398,700.00	640,659,054.97	53,739,645.03
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	3,300,000.00	-3,300,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,300,000.00	-3,300,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,300,000.00	-3,300,000.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	55,677,680.00	55,261,741.89	415,938.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	55,677,680.00	55,261,741.89	415,938.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,377,680.00	55,261,741.89	115,938.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,840,326.00	27,815,879.20	24,446.80
210101	Үндсэн цалин	-	3,307,530.76	- 3,307,530.76
210104	Урамшуулал	-	104,681.00	- 104,681.00
210105	Гэрээт ажлын хөлс	27,840,326.00	24,403,667.44	3,436,658.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,700,037.00	3,247,552.89	452,484.11
210201	Тэтгэврийн даатгал	2,683,962.00	2,331,173.68	352,788.32
210202	Тэтгэмжийн даатгал	252,124.00	229,449.68	22,674.32
210203	ҮОМШӨ-ний даатгал	204,755.00	183,559.76	21,195.24
210204	Ажилгүйдлийн даатгал	50,802.00	44,470.40	6,331.60
210205	Эрүүл мэндийн даатгал	508,394.00	458,899.37	49,494.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,125,177.00	3,125,176.80	0.20
210301	Гэрэл, цахилгаан	149,797.00	149,797.00	-
210302	Түлш, халаалт	2,975,380.00	2,975,379.80	0.20
2104	Хангамж, бараа материалын зардал	3,818,200.00	3,818,200.00	-
210401	Бичиг хэрэг	1,650,000.00	1,743,050.00	- 93,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	770,000.00	697,750.00	72,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,398,200.00	1,377,400.00	20,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,243,940.00	15,424,433.00	- 1,180,493.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,418,950.00	7,418,950.00	-
210602	Тавилга	-	1,180,493.00	- 1,180,493.00
210604	Урсгал засвар	6,824,990.00	6,824,990.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	450,000.00	250,000.00	200,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	450,000.00	250,000.00	200,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	1,580,500.00	619,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	1,580,500.00	619,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	300,000.00	-	300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	300,000.00	-	300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	300,000.00	-	300,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,558,943.00	59,100,298.00	- 6,541,355.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,558,943.00	59,100,298.00	- 6,541,355.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,418,950.00	7,718,950.00	- 300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,404,643.00	3,404,643.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,735,350.00	47,976,705.00	- 6,241,355.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр баримтлах бодлого хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлж ажиллах чиг үүрэг бүхий ЗГХА-ГБХЗХГ тайлангаа нэгтгэдэг Хөдөлмөр нийгэм хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигт туссан зорилт, үйл ажиллагаа, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа, хуулиар нийтлэг олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр зохион байгуулах үйл ажиллагаа гэсэн 4 зорилтын хүрээнд 46 хэрэгжүүлэх арга хэмжээтэй боловсруулан ЗГХА-ГБХЗХГ-ын дарга, аймгийн Засаг даргатай тус тус байгуулж, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Төсвийн шууд захирагчийн ЗГХА-ГБХЗХГ-ын даргатай байгуулсан гэрээний биелэлт 96,2%, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт 96,4%-тай хэрэгжсэн байна. Аймгийн Засаг дарга Хөдөлмөр нийгэм хамгааллын Сайдтай байгуулсан орон нутагт төлөөлөл хэрэгжүүлэх гэрээний 25 заалтыг хяналтад авч, 97.6%-тай хэрэгжсэн байна.

“Хүүхдийн тусламжийн утас-108”-д 196 дуудлага мэдээлэл бүртгэгдэж сумдын хамтарсан баг, дэмжих багуудад шилжүүлэн ажиллаж шийдвэрлэлт 96,4% байна. Ирсэн дуудлага мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 7 нэгжээр өссөн үзүүлэлттэй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус газар нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Хамтарсан багийн ажиллах үйл ажиллагааг санхүүжүүлэх журам, Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх журам, Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр хамгаалах журам, Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн дүрэм, Хүүхдийн элчийг сонгон ажиллуулах журам, Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг, Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж, Залуучуудын сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах журам зэргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Хөдөлмөрийн тухай хууль шинэчилсэнтэй холбогдуулан байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг 2022 оны 03 дугаар сард хамт олны хурлаар хэлэлцүүлэн газрын даргын 2022 оны А/16 тоот тушаалаар батлан ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн а/58 дугаар тушаалаар байгууллагын дотоод хяналтын ажлын хэсэг, ажиллах журмыг байгуулсан байна. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх 9 арга хэмжээтэй төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлт 96,6 хувьтай хэрэгжсэн байна.

Баянцагаан, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцогт, Зуунмод, Сэргэлэн сумдын Хүүхдийн төлөө зөвлөл, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, Хамтарсан багийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн А/41 тоот тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 161,317.4 мянган төгрөгөөр буюу 9,1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	3,300.0	3,300.0
Авлага	7,598.9	3,838.5	-3,760.4
Бараа материал	40,434.5	23,970.0	-16,464.5
Үндсэн хөрөнгө	1,718,624.3	1,574,231.8	-144,392.5
Нийт хөрөнгө	1,766,657.8	1,605,340.4	-161,317.4
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,766,657.8	1,605,340.4	-161,317.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,766,657.80	1,605,340.4	-161,317.4

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө 3,300.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь тайлант онд байгууллагын дэргэд ахмадын сан байгуулан, цалингийн зардлаас мөнгөн хөрөнгө төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Авлага дансны оны эхэнд 2021 оны жилийн эцэст үндсэн үйл ажиллагааны орлогын дутуу зарцуулсан 7,418.9 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэн орлогыг санхүүгийн тайланд авлагаар тусгасан байсныг аймгийн Засаг даргын А/228 тоот захирамжаар нэмэлт дансанд төвлөрүүлэн авлагыг барагдуулсан ба 2022 онд буцаан төвлөрүүлсэн 3,838.5 мянган төгрөгийн авлагыг шинээр бүртгэсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 23,970.0 мянган төгрөг болж өмнөх оноос 16,464.5 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь тусгай зориулалтай материал, бичиг хэргийн болон түлш шатах тослох материалын оны эхний үлдэгдлийг тайлант хугацаанд зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,574,231.8 мянган төгрөг болж өмнөх оноос 144,392.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 859,341.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 41,735.5 мянган төгрөг, нийт зарлагыг 901,077.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагч болон аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 157,191.4 мянган төгрөгөөр бууруулан улсын төсвөөс 702,150.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 41,735.5 мянган төгрөг, нийт 743,885.8 мянган төгрөгийг баталсан байна.

Энэ нь төсвийн захирагчаас хүргүүлсэн төсвийн төслийн саналаас цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, хүүхэд хамгааллын зардлуудыг бууруулж баталсантай холбоотой байна.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь 2022 оноос эхлэн ЗГХА-ГБХЗХГ-аас нэгдмэл удирдлагатай болж улсын төсвөөс бүрэн санхүүжилт авсан ба үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн А/140 дугаар захирамжаар 41,735.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 7,751.6 мянган төгрөгөөр бууруулж, 694,398.7 мянган төгрөгөөр тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 694,398.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 41,735.5 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 694,398.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 47,976.7 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 640,659.0 мянган төгрөг буюу 92,3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийн 53,739.6 мянган төгрөгийг дутуу буюу цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	72207-Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал /арга хэмжээ/	523,275.3	473,166.1	50,109.2	90.4%
2	72207-Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 80236- Эрсдэлийн болон НБҮ-хийх /арга хэмжээ/	4,840.0	4,750.3	89.7	98.1%
3	72207-Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 80237- Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал / арга хэмжээ/	18,907.7	18,907.7	0	100%
4	72207-Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 80238- Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал /арга хэмжээ/	63,976.8	63,735.8	241.0	99.6%
5	72207-Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 80802 -Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	52,988.6	52,988.6	0	100%

6	72209- Залуучууд болон оюутнууд хөтөлбөрийн 83115-Нийгмийн бүлэгт чиглэсэн арга хэмжээ /арга хэмжээ/	20,910.3	19,865.6	1,044.7	95.0%
7	72212- Гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөрийн 83115Нийгмийн бүлэгт чиглэсэн /арга хэмжээ/	9,500.0	7,244.9	2,255.1	76.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 47,976.7 мянган төгрөг, ХНХЯ-аас ширээ сандлын үнэнд 3,404.6 мянган төгрөг, АЗДЗ№А/130-аар 2021 оны урианы жилийн ажлын үр дүнгийн урамшуулалд 300.0 мянган төгрөг, ЗДЗ№А/228 тоот захирамжаар өмнөх оны төсөвт буцаан төвлөрүүлсэн 7,418.9 мянган төгрөг, нийт 59,100.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээнд 55,261.7 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 3,838.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Энэ нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлууд хэмнэгдсэн нь нөлөөлсөн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 3 хөтөлбөрийн 7 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	/мянган төгрөгөөр/	
					Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	72207-Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөр	1 жил	100%	92%	663,988.4	613,548.0
2	72209- Залуучууд болон оюутнууд хөтөлбөр	1 жил	100%	95%	20,910.3	19,865.0
3	72212- Гэр бүлийн хөгжил, хамгаалал хөтөлбөр	1 жил	100%	76%	9,500.0	7,245.0

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу өв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Майцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 07/34 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2022 оны баталсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын батлагдсан төсвийн 2022 оны нийт зарлага 668,473.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 10,027.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,520.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээгээр цахим хэлбэрт шилжүүлэх замаар, байгууллагаас зохион байгуулж буй нийтийг хамарсан үйл ажиллагааг facebook, байгууллагын цахим хаяг, пэйж хуудсаар дамжуулж, сургалт семинарыг 5 удаа цахимаар зохион байгуулж шатахуун болон томилолтын зардлыг хэмнэж ажилласан байна. Оны эцэст төсвийг хэмнэж, зарцуулаагүй үлдэгдэл 53,739.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс 3 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй ба цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36,877.3 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт бүрэн нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 8-ны өдөр 07/156 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,900.0	2	1,900.0	100
Албан шаардлага	1	24,832.7	1	24,832.7	100
Зөвлөмж	2	0	2	0	100
Нийт дүн	5	26,732.7	5	26,732.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дараагийн аудитаар Хүүхдийн хөгжил хамгаалал хөтөлбөрийн зарцуулалтад анхаарал хандуулах

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 4,745.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 4,745.5 мянган төгрөгийн алдааг залруулав. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн уялдааг шалгахад үндсэн хөрөнгийн тодруулгаар 10,474.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр бүртгэснийг мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардалд бичих тохируулгыг 4,544.6 мянган төгрөгөөр, санхүү үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 200.9 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “толилуулга”, “оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийгдсэн.

Аудитаар нийт 41,561.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,383.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 3,300.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 36,877.3 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдсөн.

5.1 Төлбөрийн акт

1. Сургалт арга хэмжээний зардлыг түүвэрлэн шалгахад сумдын нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийн чадавхжуулах сургалтыг 2022 оны 4 дүгээр сарын 12, 13-ны өдөр зохион байгуулахад албан томилолтын зардлыг давхардуулан 1,383.9 мянган төгрөгийн хоол, цайны зардал олгосон зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “үр ашигтай байх”, 4.2.1-д “зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.6-д “эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Төв аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Ахмадын сан байгуулах тухай” А/148 тоот тушаалаар байгууллагын дэргэд ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг баталж, төрийн санд данс нээлгүүлж, санд шаардагдах хөрөнгийг тухайн жилийн төсөвт тусгаагүй байхад 3,300.0 мянган төгрөгийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3-д “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэж заасныг болон санхүүгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн албан шаардлага бичив.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн бараа үйлчилгээний /210801/ зардлын 36,7 хувийг бараа материал, хулдаасан хэвлэл, өргөмжлөлийн үнэнд, 16,2 хувийг хоол цай, айраг, ааруул, бялууны үнэнд, 10,3 хувийг албан томилолтын болон шатахууны үнэнд, 8,7 хувийг шагналд зарцуулсан нь төсвийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-д “сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан зардлыг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулбал зохих мэдээллээс 3 мэдээллийг байршуулаагүй төлөвтэй ба цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 36,877.3 мянган төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” гэж заасантай бүрэн нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансанд байршуулах мэдээллийг цаг хугацаанд нь иж бүрэн мэдээлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Буруу тусгасан	1	4,745.5			1	4,745.5	1	4,745.5				
Дүн	1	4,745.5			1	4,745.5	1	4,745.5				

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн
Ахмадын сан	1	3,300.0			1	3,300.0						
Үрэлгэн зарцуулсан	1	1,383.9	1	1,383.9								
Зардал	1	0					1	0				
Дүн	3	4,683.9	1	1,383.9	1	3,300.0	1	0				

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дутуу байршуулсан	1	36,877.3					1	36,877.3
Дүн	1	36,877.3					1	36,877.3
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	36,877.3					1	36,877.3